



SHARYN GOL JSC

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2, 3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 16:00 цагаас “Корпорейт” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - А. Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлан.
 - Б. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаалагдаагүй хувьцааг хасах эсэх тухай.
 - В. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
 - Г. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2015 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах.
 - Д. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг 2015 оны 3 сарын 20-ны өдөр байхаар тогтоосугай.
4. Хуралд хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдрийг 2015 оны 3 сарын 10, санал авах хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөр тус тус тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг /хавсралт 1/-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдож хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг /хавсралт 2/ тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/, СТХ /Л.Даваасүрэн/ нарт даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн дарга Б.Батмөнхийг томилсугай.

8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд: Комиссын дарга: Б.Батмөнх

Гишүүд: Д.Байлхүү – ТУЗ-ийн гишүүн
Жеймс Пассин - ТУЗ-ийн гишүүн
Б.Батбаатар - ТУЗ-ийн гишүүн
Б.Отгонзул – БХХОХ Захирал
Л.Батсуурь – ТУЗ-ийн н/б дарга

9. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд: Комиссын дарга : Л.Эрхбаатар –Дэд захирал

Гишүүд: Д.Даянбилгүүн - ТУЗ-ийн гишүүн
Л.Оюундарь – Эдийн засагч

10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргаж зохих хууль, журмын дагуу хуралдуулахыг комисс /Б.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАТМӨНХ

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 16⁰⁰ цагаас “Корпорейт” зочид буудлын танхимд болох тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Бүртгэлийн өдөр: 2015 оны 3-р сарын 20-ны өдөр

Хуралд хэлэлцэх асуудал

1. Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайланг батлах
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаалагдаагүй хувьцааны талаарх асуудлыг шийдвэрлэх
3. Компанийн ТУЗ-ийн ердийн, хараат бус гишүүдийг сонгох
4. Компанийн ТУЗ-ийн 2015 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
5. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

Хуралд хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй харъяа брокер диллерийн компаниуд болон СБД, 1-р хороо “Ланд марк” оффисийн барилгын 4 давхарт байрлах компанийн төлөөлөгчийн газарт ажлын цагаар танилцах буюу дараах утсаар лавлана уу.

Утас: 976-11-311073

99293913

99031917

Электрон шуудан: otgonzul@sharyngol.com

Хурал зохион байгуулах комисс

**“Шарын гол” ХК-ийн хувьцааны
5%-с дээш багцыг эзэмшигчид**

д/д	Хувьцааны эзэмшигч	Хувьцааны тоо	Эзлэх хувь	Тайлбар
1	SHG HOLDINGS 3	2,318,451	22,66	
2	SHG HOLDINGS 2	2,028,906	19,86	
3	NIHAN HOLDINGS	1,598,889	15,63	
4	Б.Баярсайхан	1,158,529	11,32	
5	SHG HOLDINGS 1	1,142,674	11,17	
6	MOGUL RESOUPCES	1,000,000	9,77	
	Нийт	9,247,449	90,4	

2014 оны 12 сарын 31-ний байдлаар “Шарын гол” ХК-ийн хувьцааг нийт 1,057 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бөгөөд үүнээс нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигчийг дээрх хүснэгтээр үзүүлэв.

Мэдээлэл

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 93,7 хувийн ирцтэйгээр хуралдлаа.

Хуралд:

- Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайланг хэлэлцэж хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар уг тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг баталсан тухай тогтоол дугаар 01-ийг,
- Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаагүй хувьцааг хасах тухай асуудлыг хэлэлцэж хуралд санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар уг хувьцааг хасахаар тогтсон тухай тогтоол дугаар 02,
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны цалин урамшуулал, зардлын төсвийн тухай хэлэлцэж хуралд санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар баталсан тогтоол дугаар 03,
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай хэлэлцэж санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 100 хувийн саналаар ердийн гишүүдэд Б.Батмөнх, Б.Батбаатар, Ж.Батболд, Грам Чапман, Д.Даянбилгүүн, Жеймс Пассин нарыг, хараат бус гишүүдээр Д.Байлхүү, Кеннет Фаррелл, Жозеф Найэми нарыг сонгож баталсан тухай тогтоол дугаар 04-ийг тус тус баталлаа.
- Компанийн 2014 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсныг мэдээлж байна.

Хурал зохион байгуулах комисс

Харилцах утас: 976-11-311073, 99293913, 99031917

Электрон шуудан: otgonzul@sharyngol.com